

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.080.99

Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага	MNS 5546:2005
General requirements for assessment of soil erosion and degradation of vegetation cover in pasture lands	

Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2005 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 56 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын зорилго нь бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлын зэрэглэлийг тогтооход оршино.

Энэ стандартыг бэлчээрийн газрын чанар, төлөв байдал, экологит үнэлгээ өгөх, газар ашиглагч, эзэмшигч нарын зүгээс хөрсний үргжил шим, ургамал нөмрөгт үзүүлж буй өөрчлөлтийг тодорхойлоход баримтлана.

## 1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлын төлөв байдлыг хээрийн нөхцөлд тогтоош шалгуур болно. Эдгээр үзүүлэлтийг нарийвчлан тогтооход итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт болон бусад нэмэлт мэдээллийг ашиглана.

## 2. Норматив ишлэл

Энэ стандартад дараах баримт бичиг, аргачлалаас ишлэл хийсэн бөгөөд тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

- 1) Энэхүү стандартыг Д.Аваадорж, Я.Баасандорж, С.Бадрах нар Монгол орны бэлчээрийн газрын хөрс, ургамал нөмрөгийн шинж чанар, төлөв байдлын өөрчлөлт, доройтлын талаар сүүлийн 15 жил судалгааны ажлын үр дүн, дүгнэлтдээ үндэслэн боловсруулав.
- 2) Гадаад, дотоодын судлаачид боловсруулсан аргачлал, арга зүйн зарчмыг энэхүү стандартыг боловсруулахад ашиглав (Ашигласан ном хэвлэлийг үз).

### **3. Тодорхойлолт**

Бэлчээрийн хөрс, ургамал нөмрөгийн шинж чанарыг үнэлж, түүний элэгдэл эвдрэл, талхлагдлын зэрэглэлийг тогтооход доорхи үндсэн үзүүлэлтийг үндэс болгоно.

**Хөрсний элэгдэл эвдрэл** – Хөрсний эгэл хэсэг усаар угаагдаж, салхиар хийсч, үүссэн анхны газраасаа зөөгдөж өөр газар шилжин байрлаж тогтоц, шинж чанараа алдах үзэгдлийг;

**Ургамлын талхлагдал** – Хүн, мал амьтны нөлөөгөөр бэлчээрийн ургамлын үндсэн төрөл, бүрхэвч өөрчлөгдөж чанар, чадавхи нь муудах үзэгдлийг;

**Талхагдлын заагуур ургамлын тусгаг бүрхэц** – Талхлагдсан бэлчээрийн газрын нэгж гадаргууд малын иддэггүй ургамлын хэмжээ, эзлэх хувь;

**Элсэн хуримтлалын зузаан** – Салхины нөлөөгөөр зөөгдөж хуримтлагдсан элсний зузаан, см;

**Хөрсний ялзмагт үеийн нэлэнхүй нимгэрэлт ба зулгаралт** – Салхи, усны хүчин дор хөрсний ялзмагт үеийн зузааны бууралтын хувь;

**Нэг км<sup>2</sup> талбайд ногдох гуу жалга, сайрын урт, м;**

### **4. Туршилт явуулах хугацаа, арга**

Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэлийг хавар, зун харин ургамлын талхлагдлыг зуны улиралд тус тус тодорхойлно.

Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг хөрс, ургамлын бичиглэл хийж энэхүү стандартад тусгагдсан үзүүлэлтийг тодорхойлж хэвийн бэлчээртэй харьцуулан өөрчлөлтийг тогтооно.

Хэвийн бэлчээрт хамгийн сайн ургацтай бэлчээрийн төрлийг сонгож авна.

### **5. Ашиглах багаж, хэрэгсэл**

- 5.1. Хөрс, ургамлын бичиглэлийн маягт
- 5.2. Ургамлан бүрхэвч, ургамлын зүйлийн тоог тодорхойлох тортой жааз
- 5.3. Солбицол, үнэмлэхүй өндрийн багаж, GPS
- 5.4. Метр
- 5.5. Хүрз
- 5.6. Хөрсний өрөм
- 5.7. Дээжний уут
- 5.8. Хайч
- 5.9. 1,0; 0,5; 0,1 мм-ийн шигшүүрийн иж бурдэл

6. Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэлийг тогтооход дараах үзүүлэлтийг ашиглана. Үүнд:

- 6.1. Зөөгдөж хуримтлагдсан элсний зузаан, см
- 6.2. Хөрсний ялзмагт үеийн нимгэрэлт, хувь
- 6.3. 1,0 мм-ээс бага голчтой бөөнцөрийн эзлэх хэмжээ, хувь
- 6.4. Нэг км<sup>2</sup> талбайд ногдох гуу жалга, сайрын урт, м

7. Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэлийн зэрэглэл тогтоох шалгуур

1-р хүснэгт

№	Хөрсний элэгдэл эвдрэлийн зэрэглэл	Зөөгдөж хуримтлалын элсний зузаан, см	1,0 мм-ээс бага голчтой бөөнцөрийн эзлэх хэмжээ, хувь	Хөрсний ялзмагт үеийн нимгэрэлт, %	Нэг км <sup>2</sup> талбайд ногдох гуу жалга сайрын урт, м
0	1	2	3	4	5
1	Сул	5-15,9	20-30	5-10	100-300
2	Дунд зэрэг	16-30,9	31-40	11-20	301-500
3	Хүчтэй	>31	>40	>21	>501

8. Бэлчээрийн ургамлын талхлагдлыг тогтооход дараах үзүүлэлтийг ашиглана. Үүнд:

- 8.1. Малын иddэг ургамлын эзлэх хувь
- 8.2. Талхлагдлын заагуур ургамлын тусгаг бүрхэц, хувь
- 8.3. Нэгж талбайд байгаа талхлагдлын заагуур ургамлын зүйлийн нэр, тоо
- 8.4. Ургацын бууралт, хувь

9. Бэлчээрийн ургамлын талхлагдлын зэрэглэл тогтоох шалгуур

2-р хүснэгт

№	Талхлагдлын зэрэглэл	Малын иddэг ургамлын эзлэх хувь	Талхлагдлын заагуур ургамлын тусгаг бүрхэц, %	Талхлагдлын заагуур ургамлын зүйлийн тоо	Ургацын бууралт, хувь
0	1	2	3	4	5
1	Сул	51<	10-30	1-2	20-40
2	Дунд зэрэг	20-50	31-50	3-4	41-60
3	Хүчтэй	<20	<51	>5	>61

## **ХАВСРАЛТ А (мэдээллийн)**

### **Ашигласан ном, хэвлэл**

- 1) М.Н.Заславский "Эрозиоведение" /1983/
- 2) П.Д.Гунин, Е.А.Востокова "Методология оценки состояния и картографирования экосистем в экстремальных условиях", Пущино. 1993, 203 с.
- 3) H.E.Dregne, 1986. "Desertification of arid lands" // In Physics of Desertification, ed. F.El-Baz and M.H.A.Hassan. Dordrecht, The Netherlands: Martinus, Nijhoff.
- 4) Liu Zhongling, Hao Dunyuan "The Ecosystem Conservation and Sustainable Development of the North Steppe of China" // The International Conference on The Optimum Allocation of water Resource The Ecological Environment Construction and The Sustainable Development in Arid Zone. Huhhot. 2002, 345-370 p.
- 5) Н.Манибазар "Монголын ногоон алт, малын бэлчээрийн ургамлын цэс" Улаанбаатар, 2000
- 6) О.Чогний "Мал бэлчээсний улмаас экосистемд гарах талхагдлын зэргийн үнэлгээ". Улаанбаатар, 1993